

Зургийн бүрдэл, тайлбар бичиг

Тайлбар

Хуудасны марк	Нэр	Тайлбар
ХТ-1	Зургийн бүрдэл, тайлбар бичиг	
ХТ-2	Деталиуд	
ХТ-3	Материалын түүвэр, таних тэмдэг тооцооны бүдүүвч	
ХТ-4	Оүчит төхөөрөмжийн байгуулалт	
ХТ-5	Дээврийн аянга хамгаалалтын байгуулалт	
ДГ-1	Аэрэлтүүлгийн байгуулалт	

барилгын засварын ажлын зураг төслийг барилга архитектур, технологийн даалгаварыг үндэслэн цахилгааны хэсгийн ажлын зургийг хийж гүйцэтгэв. Энд олон нийтийн барилгын цахилгааны зураг төсөл зохиох БНБД 23-02-08, БД 43-102-07 болон бусад холбогдох норм дүрмийн дагуу хийж гүйцэтгэв.

Тэжээлийн болон группын шугам:

Тус багт цахилгааны эх үүсвэр байхгүй тул 3 кВт-ын чадалтай бага оврын зөөврийн цахилгаан үүсгүүртэй ХОНДА мотор байхаар төлөвлөв.

Самбар тоног төхөөрөмжийн тэжээлийн магистраль шугамд ВВГ-П маркын утсуудыг шалны бэлтгэл, тусгай зориулалтын хийцээр пластмассан хоолойд сүвлэж далд явуулна.

Гэрэлтүүлгийн группын шугамд ППВ маркын утсыг ханаар шавардлага дор далд, таазаар хавтангийн нүхээр галд тэсвэртэй РҮС хоолойд сүвлэн далд тавина.

Дотор гэрэлтүүлэг:

Ажлын гэрэлтүүлгийн хүчдэл 220В

Гэрэлтүүлгийг

БНБД 23-02-08 -ийн дагуу ерөнхий ба ажлын байрны зориулалтаар төлөвлөж, гэрэлтүүлэгчдийг ерөөний нөхцлөөс хамааруулан сонгож авсан болно. Унтраалгыг хаалганы бариултай талд шалнаас 1.6м-ийн өндөрт, хаалганы онгойлттой хэсгээс 20см-ийн зайнд байршуулж өгнө. Розеткуудыг ерөөний нөхцөл тавилгын байрлалаас хамааран шалны түвшнээс дээш 0.3-1.8 м-ийн өндөрт тоноглоно. Гарах орох гарцанд "Гарах" бичигтэй өөр дээрээ цэнэг хуримтлууртай гэрэлтүүлэгч тавина. зурагт заасан хэсгүүдэд өөр дээрээ цэнэг хуримтлууртай ослын гэрэлтүүлгийг тавина.

Газардуулга ба аянга хамгаалалт:

Аянгаас хамгаалах зураг төсөл хийх БД 43-103-08 зааврын дагуу аянга хамгаалалтыг хийнэ.

Уг барилга нь аянга хамгаалалтын 4-р зэрэгт орно.

Уг барилгын аянга хүлээн авагчийг металл дээвэр байхаар тооцов.

Аянгын гүйдэл дамжуулагчийг 25*4мм туузан төмрийг барилгын ханын дагуу 12м тутамд буулгаж гадна газардуулгын босоо электродтой холбож өгнө.

Барилгыг тойруулан 40*4 ган туузаар газардуулгын хүрээ хийж босоо электродтой холбох.

Дээвэр дээр байгаа металл хийцүүдийг аянга хүлээн авагчтай сайтар холбож өгнө.

Электродыг 40х40х4мм-ийн булан төмрөөр хийх ба өөр хоорондоо 3м зайтайгаар газарт зоож газрын хөрснөөс 0.7м-ийн гүнд 40х4мм-ийн туузан гангаар холбож /гагнаж/ булна. Энд газардуулгын эсэргүүцлийн хэмжээ 4 Ом-оос ихгүй байх шаардлагатай ба хэмжиж үзээд илүү гарсан тохиолдолд нэмэлт электрод зоож өгнө.

Газардуулгуудыг хийх үед зохиогчийн хяналт заавал хийлгэх шаардлагатай ба фото зургаар баталгаажуулах.

Угсралтын ажлыг цахилгаан байгууламжийн дүрэм БД 43-101-03, Цахилгаан техникийн аюулгүй ажиллагааны дүрэм ба

Цахилгаан техникийн угсралтын БНБД 03-05.06-90 нормын дагуу мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

Хүмүүсийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор хэвийн нөхцөлд гүйдэл дамжуулдаггүй боловч хөндийрүүлэгч гэмтсэн тохиолдолд хүчдэлтэй болж болох тоног төхөөрөмжийн их биеийг газардуулж өгнө.

Угсралтын ажлыг цахилгаан байгууламжийн дүрэм БД 43-101-03, Цахилгаан техникийн аюулгүй ажиллагааны дүрэм ба Цахилгаан техникийн угсралтын БНБД 03-05.06-90 нормын дагуу мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

Үндсэн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлтийн нэрс	Хэмжих нэгж	Тоон утга
1	Сүлжээний хүчдэл	Вольт	220
2	Суурилагдсан чадал	кВт	1.60
3	Тооцооны чадал	кВт	1.28
4	Тооцооны гүйдэл	Ампер	7.3
5	Хүчдэлийн максимум алдагдал	%	